



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2014 оны 05 сарын 04 өдөр

Дугаар 162

Улаанбаатар хот

“Компанийн засаглалын кодекс”-ийг  
шинэчлэн батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2 дахь заалтыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Компанийн засаглалын кодекс”-ийг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Кодекс шинэчлэн батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн “Компанийн засаглалын кодекс багтах тухай” 210 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.
3. Монголын хөрөнгийн биржийн “А” самбар дээр бүртгэлтэй хувьцаат компаниуд энэхүү кодексийг хэрэгжүүлж ажиллах ба бусад хувьцаат компаниуд хэрхэн хэрэгжүүлж байгаа талаараа тайлбарлаж ажиллахыг үүрэг болгосугай.
4. Нийт компаниуд энэхүү кодексийг мөрдлөг болгон ажиллахыг зөвлөсүгэй.
5. Шинэчлэн батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Д.Болормаа/, Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд тус тус үүрэг болгосугай.


ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000165

Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 5 дугаар  
сарын 04 ны 162 тогтоолын хавсралт



# КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС

2014

## АГУУЛГА

Оршил

Бүлэг 1. Компанийн засаглалын суурь үндэс

Бүлэг 2. Хувьцаа эзэмшигчдийн эрх

Бүлэг 3. Мэргэжлийн хөрөнгө оруулагчид

Бүлэг 4. Хувьцаа эзэмшигчдийн хурал

Бүлэг 5. Төлөөлөн удирдах зөвлөл

Бүлэг 6. Гүйцэтгэх удирдлага

Бүлэг 7. Санхүүгийн тайлагнал, мэдээллийн ил тод байдал

Бүлэг 8. Дотоод хяналтын тогтолцоо

Бүлэг 9. Эрсдэлийн удирдлага

Бүлэг 10. Оролцогч талууд

## ОРШИЛ

Улс орны компанийн засаглалын хөгжлийн түвшин, үр дүнтэй байдал нь эрх зүйн зохицуулалтаас гадна компанийн зохистой засаглалын хэм хэмжээний төлөвшил, бизнесийн ёс зүй, зан заншил, оролцогчдын мэдлэг чадвар, туршлага зэрэг олон хүчин зүйлээс хамаардаг байна.

Ил тод байдал, үр ашигтай зах зээл, хууль тогтоомжийг дээдлэх ёсыг төлөвшүүлэх, удирдах, зохицуулах, хэрэгжүүлэх эрх мэдэл, үүрэг хариуцлагыг зааглан тогтоохыг хөхүүлэн дэмжих нь компанийн зохистой засаглалын үндсэн зорилго билээ.

1999 онд анх баталж, улмаар 2004 онд нэмэлт, өөрчлөлт оруулаад байгаа Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас баталсан “Компанийн засаглалын зарчмууд”-ыг жинхэнэ утгаар нь нэвтрүүлэх талаар төрийн бодлогын хэмжээнд анхаарч, ач холбогдол өгч байна.

Монгол Улсын гэх Компанийн засаглалын кодексийг Дэлхийн банкны дэргэд дэх Олон Улсын Санхүүгийн Корпораци зэрэг олон улсын байгууллагуудын зөвлөмж, зөвлөгөө, дэлхийн бусад улс орны туршлага, өөрийн орны онцлог, бодит нөхцөл байдал, компанийн засаглалын эдийн засагт үзүүлэх нөлөө, зах зээлийн шударга байдал, зах зээлд оролцогчдын хувьд үзүүлэх эерэг нөлөө зэрэг асуудлыг харгалзан үзсэний үндсэн дээр боловсруулсан.

Энэхүү кодексийг хувьцаа нь нийтэд чөлөөтэй арилжаалагддаг, нээлттэй буюу хувьцаат компанид тухайлан зориулж боловсруулсан бөгөөд хязгаарлагдмал хариуцлагатай компани болон бусад хуулийн этгээдийн тухайд өөрийн онцлогт тохируулан хэрэглэх боломжтой юм.

Манай улсын компани бүр компанийн засаглалын зарчмуудыг үйл ажиллагаандаа хэвшил болгож улмаар компанийн тогтвортой хөгжил, хөрөнгө оруулалтын таатай нөхцөлийг бүрдүүлэн, эдийн засгийн эрчимтэй өсөлтийг хангахад чухал хувь нэмэр оруулах болно.

---oOo---

## **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН СУУРЬ ҮНДЭС**

1.1. Үндэсний хууль тогтоогч, зохицуулагч байгууллага нь компанийн засаглалын тогтолцоог бий болгон түүнийг нэвтрүүлэхдээ олон улсын хэмжээнд гэрээ, хэлэлцээ хийх болон хамтын ажиллагааг хөгжүүлэх, үйл ажиллагааны үр ашгаа нэмэгдүүлэхэд ямар чухал үүрэг гүйцэтгэхийг зохих ёсоор үнэлэх шаардлагатай. Тухайн нөхцөлийг харгалзан үзэж чадвал хэт зохицуулалтаас зайлсхийх, хувийн хэвшлийн бизнесийг дэмжих, хувийн болон олон нийтийн институт хоорондын ашиг сонирхлын зөрчлийг хязгаарлаж чадна. Энэхүү нөхцөлийг хангахын тулд зохицуулагч байгууллага дараах зарчмуудыг баримталж ажиллах нь зохистой:

1.1.1. Эдийн засагт үзүүлэх нөлөө, зах зээлийн нээлттэй, ил тод, шударга, үр ашигтай байдлыг хангах, зах зээлд оролцогчдыг урамшуулах зэрэг асуудлыг харгалзан үзсэний үндсэн дээр засаглалын кодексийг боловсруулах;

1.1.2. Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэхэд нөлөөлөх эрх зүйн зохицуулалт болон дүрэм, журамд тавигдах шаардлага нь хуулийг дээдлэн ил тод хэрэгжүүлэх боломжтой байх;

1.1.3. Эрх бүхий этгээд хоорондын үүрэг хариуцлагын хуваарилалтыг нийтийн эрх ашигт нийцүүлэн тодорхойлдог байх;

Эрх мэдлийг хэрэгжүүлэх боломж, ажлын үнэлгээ болон хүлээсэн үүрэг, хариуцлага, тайлагналын шаардлагыг өндөржүүлэн олон улсын хэм хэмжээнд хүргэх шаардлагатай.

1.1.4. Зохицуулах, хэрэгжүүлэлтэд хяналт тавих албан тушаалтнууд нь хариуцсан үүргээ мэргэжлийн түвшинд хэрэгжүүлэх эрх мэдэлтэй, шударга байх ба тэдний гаргаж байгаа аливаа шийдвэр нь ойлгомжтой, цагаа олсон, ил тод байна.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ**

2.1. Хувьцаа эзэмшигчдийн эрхийн асуудал нь компанийн засаглалын тогтолцооны нэг чухал үзүүлэлт тул тэдгээрийн эрхээ хэрэгжүүлэх нөхцөлийг компани бүрдүүлсэн байна. Хувьцаа эзэмшигч нь оруулсан хөрөнгийнхөө хувь хэмжээгээр эрсдэл хүлээдэг. Иймд хувьцаа эзэмшигчид компанийн дүрэмд тусгагдсан онцгой шийдвэрийг гаргахад

оролцох, компанийн үйл ажиллагаанд хяналт тавих боломжтой байна. Үүний тулд дараах эрхүүдийг компани баталгаажуулсан байх ёстой.

- компанийн үйл ажиллагаатай холбоотой гаргаж буй чухал шийдвэр гаргахад оролцох;
- компанийн үйл ажиллагааны талаар мэдээлэл авах;
- компанийн ашгаас ногдол ашиг хүртэх;
- компанийн хийж буй их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг хянах;
- компанийг татан буулгахад үлдсэн эд хөрөнгөөс эзэмшиж буй хувьцаанд ногдох хувь хүртэх.

2.2. Дээрх эрхийн хүрээнд хувьцаа эзэмшигч дараах эрхүүдийг эдэлнэ.

### **2.2.1. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрх**

Компанийн төлөөлөн удирдах зөвлөл хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулахаас гадна тодорхой тохиолдолд эдгээрээс өөр этгээд зарлан хуралдуулах үүрэгтэй. Хувьцаа эзэмшигч компанийн үйл ажиллагаатай холбоотой аливаа чухал асуудлын талаар шийдвэр гаргахад эзэмшиж буй хувьцааны саналын эрхээр оролцох бололцоогоор хангагдсан байна.

### **2.2.2. Ногдол ашиг авах эрх**

а/Компани ногдол ашгийн бодлогоо боловсруулж хэрэгжүүлэх бөгөөд ингэхдээ хувьцаа эзэмшигч бүр компанийн ашгаас тогтмол, шударгаар хувь хүртэх, ногдол ашгийн хэмжээ нь зохистой байх зарчмыг баримтална.

б/Ногдол ашиг тодорхойлох журам ил тод байх ёстой. Үүний тулд хувьцаа эзэмшигчдээ санхүү нягтлан бодох бүртгэлийн тайлан мэдээлэлтэй танилцах боломж олгож хэвшсэн байна.

в/Ногдол ашиг тараах шийдвэр гаргаснаас хойш боломжит богино хугацааны дотор хувиарладаг байна.

г/Ногдол ашиг хувиарилаагүй бол түүний шалтгааныг хувьцаа эзэмшигчдэд тайлагнадаг байна.

д/Ногдол ашиг хувиарлалтын тайланг дараагийн хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнадаг байх нь зүйтэй.

е/Ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэд хялбар арга, хэлбэрээр хүргэх боломжийг бүрдүүлсэн байна.

### **2.2.3.Санал өгөх тэгш эрх**

а/Хувьцаа эзэмшигч нь эзэмшиж буй хувьцааны хэмжээнээс хамаран хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэх асуудалд оролцох оролцоо нь өөр байх боловч уг эрхээ хэрэгжүүлэх тэгш боломжоор хангагдсан байна.

б/Компани хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхийг хязгаарласан аливаа үйл ажиллагаа явуулахаас зайлсхийх ба давуу эрхийн хувьцаа эзэмшигчид компанийг өөрчлөх эсвэл татан буулгах зэрэг тэдгээрийн эрхийг хязгаарлахтай холбоотой асуудалд санал өгдөг байх ёстой.

### **2.2.4.Сонгох ба сонгогдох эрх**

а/Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлагыг сонгох ажиллагааг ил тод, нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр явуулах зарчмыг үйл ажиллагаандаа баримталдаг байна.

б/Төлөөлөн удирдах зөвлөлийн нэр дэвшигчдийн дэлгэрэнгүй мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд цаг тухайд нь нэгэн зэрэг хүргэж мэдээлэх тогтолцоог бүрдүүлсэн байна. Гүйцэтгэх удирдлага болон төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын гишүүдийн талаар мэдээллийг мөн мэдээлнэ.

### **2.2.5.Мэдээлэл авах эрх**

а/Компанийн талаарх мэдээллийг хувьцаа эзэмшигчид тогтмол болон цаг тухай бүр нэгэн зэрэг шуурхай авах эрхээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна. Зайлшгүй хүргэх мэдээлэлд компанийн жилийн тайлан, санхүүгийн нөхцөл байдал, компанийн аливаа эрсдэл болон бусад компанийн үйл ажиллагаанд хамгийн чухал гэж үзсэн мэдээллүүд багтана.

б/Компанийн удирдлага холбогдох бүртгэлийн байгууллагын гаргасан бүртгэлийн дагуу хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг баталгаажуулсан байна. Компанийн удирдлага хувьцаа эзэмшигч хүсэлтээр хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн талаарх мэдээллийг танилцуулдаг байна.

в/Компани ямар төрлийн мэдээллийг нийтэд тогтмол болон тухай бүр хүргэх түүнтэй холбогдон гарах харилцааг зохицуулсан мэдээллийн үйл ажиллагааны журмыг боловсруулан төлөөлөн удирдах зөвлөл батлан мөрдүүлдэг байх ёстой.

#### **2.2.6.Хувьцааг эргүүлэн худалдан авахыг шаардах эрх**

а/Компанийн тухай хуульд заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлаас тодорхой шийдвэр гаргасан тохиолдолд уг асуудлаар эсрэг саналтай байсан эсхүл уг шийдвэрийг гаргахад оролцоогүй хувьцаа эзэмшигчид хүсвэл өөрсдийн хувьцааг буцаан худалдан авахыг шаардах эрхтэй байхаар компанийн дүрэмд заасан байна. Тухайлбал:

- компанийг өөрчлөн байгуулах /нийлэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх/;
- хувьцаа эзэмшигчдийн эрхийг хязгаарлах, энэ чиглэлээр компанийн дүрэмд өөрчлөлт оруулах;
- их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх шийдвэр гаргах;
- нийт хувьцааны 75 болон түүнээс дээш хувийг нэг этгээд эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмших болсон.

б/Компанийн эргүүлэн худалдан авсан хувьцаа нь ногдол ашиг авах болон саналын эрхгүй байх ба бусдад худалдсан тохиолдолд эрх сэргэнэ.

в/Дээрх 2.2.6.а болон хуулиар тогтоосон бусад тохиолдолд хувьцаа эзэмшигчид хувьцаагаа эргүүлэн худалдах эрх үүссэн тухай мэдээллийг хүргэх, эргүүлэн худалдахыг шаардсан шаардлагаа ирүүлэх, шаардлагыг хүлээн авч шийдвэрлэх эсвэл хүлээн аваагүй шалтгааныг хувьцаа эзэмшигчид мэдээлэх, үүнтэй холбогдсон хувьцаа эзэмшигчийн гомдлыг хэрхэн шийдвэрлэх зэрэг асуудлыг тусгасан тусгай журам тогтоон мөрдүүлэх ёстой.

#### **2.2.7.Нэмж шинээр гаргаж буй хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрх**

а/Хувьцаа эзэмшигчид компанийн нэмж гаргаж буй хувьцаанаас нэн тэргүүн ээлжид худалдан авах давуу эрхийг олгодог байна.

#### **2.2.8.Компанийн үйл ажиллагаанд шалгалт хийлгэхийг шаардах эрх**

а/Компани өөрийн үйл ажиллагааг тогтмол хянах дотоод болон гадаад механизмыг бүрдүүлсэн байна.

б/Компанийн нийт хувьцааны 10 болон түүнээс дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч дотоод болон хөндлөнгийн аудитаар шалгуулах эрхтэй байна.



## **2.2.9. Компанийн татан буугдахад үлдсэн хөрөнгөөс хувь хүртэх эрх**

а/Компанийг татан буулгах үйл ажиллагааны үед хувьцаа эзэмшигчид ижил тэнцүү эрхийг эдэлнэ. Компанийг татан буулгах комисс компанийн хөрөнгөөс өр төлбөрийг төлөөд үлдсэн хөрөнгийг хэрхэн хуваарилах талаар журам гаргах ба хувьцаа эзэмшигч бүрийн эзэмшиж буй хувьцааны хувь хэмжээнд тохирох хэмжээний хөрөнгийг хуваарилах үүрэг хүлээнэ.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ.**

### **МЭРГЭЖЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИД**

#### **3.1.Мэргэжлийн хөрөнгө оруулагчдийн эрх үүрэг**

3.1.1.Мэргэжлийн хөрөнгө оруулагчид өөрсдийн компанийн засаглалын бодлого мөн санал өгөх бодлого мөн түүнчлэн санал өгөх эрхийг хэрхэн хэрэгжүүлэх журмаа ил тод, нээлттэй болгосон байна.

3.1.2.Компани нь мэргэжлийн хөрөнгө оруулагчид тэдний томоохон хөрөнгө оруулалтын үйл ажиллагаатай холбогдон гарч болзошгүй ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах журмыг батлан ил тод нээлттэй болгосон байна.

3.1.3.Мэргэжлийн хувьцаа эзэмшигчид ба хувьцаа эзэмшигчид энэхүү кодекст заасан үндсэн эрхээ урвуулан /хэтрүүлж ашиглах, буруугаар ашиглах, зарчимд заасан эрхээ зөрчих/ ашиглаж үгсэн хуйвалдахаас бусад тохиолдолд өөр хоорондоо харилцан зөвлөлдөх боломжийг бүрдүүлсэн байна.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ.**

### **ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ**

#### **4.1.Хувьцаа эзэмшигчдийн хурлын эрх хэмжээ**

4.1.1.Хувьцаа эзэмшигчдийн хурал нь компанийн эрх барих дээд удирдлага байна.

4.1.2.Хувьцаа эзэмшигчдийн хурал нь хувьцаа эзэмшигчдийг дараах боломжуудаар хангана:

- компанийн үйл ажиллагааг хянах,
- компанийн үйл ажиллагааны талаар гаргаж буй чухал шийдвэрийг хэлэлцэх, шийдвэр гаргахад оролцох;
- компанийн санхүүгийн болон санхүүгийн бус бүхий л мэдээлэлийг авах;

- компанийн ногдол ашгийн бодлогыг тодорхойлоход оролцох.

4.1.3. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэх үүрэгтэй ба энэ тухай компанийн дүрэмд тодорхойлсон байвал зохино:

- компаниас үнэт цаас гаргах шийдвэр;
- компанийн хөндлөнгийн аудиторыг томилох, түүнтэй гэрээ байгуулах;
- хуулийн байгууллага, олон нийтийн байгууллага, сангуудтай компани хэрхэн хамтран ажиллах талаар гаргах шийдвэр;
- хараат охин компани байгуулах шийдвэр;
- сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох, уг хэлцлийг хийх журам;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох шийдвэр;
- Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл дүрмийн шинэчилсэн найруулга.

4.1.4. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрх, хурал хуралдуулах тухай шийдвэрийг хэн хэзээ хэрхэн гаргах, хурлаар хэлэлцэх асуудлыг хэн хариуцан хэдийд бэлэн болгох, хурлын товын талаар болон хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээллийг хувьцаа эзэмшигчд болон эрх бүхий хяналтын байгууллагад хэрхэн мэдээлэх, хурлыг хэрхэн зохион байгуулж, удирдан явуулах, санал өгөх, шийдвэр гаргах, түүнийг хэрхэн албажуулах, хурлын материалыг хэрхэн шалгаж, баримтжуулан хадгалах болон бусад холбогдох асуудлыг тусгасан хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах журмыг боловсруулан хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлан мөрдөх нь зүйтэй.

## **4.2. Хувьцаа эзэмшигчдийн хуралд бэлтгэх**

4.2.1. Холбогдох хуулийн дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахад түүний бэлтгэл ажиллагааг зохион байгуулах явдал чухал юм. Дээр дурдсан шаардлагуудыг хангаж ажиллахад дараах асуудлууд чухал:

- Хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрөөр тасалбар болгосон хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн жагсаалтыг гаргах;
- хувьцаа эзэмшигчдийг мэдээллээр хангах;
- хувьцаа эзэмшигчдийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлыг судалж танилцах нөхцөл бололцоогоор хангах.

4.2.2.Төлөөлөн удирдах зөвлөл энэхүү үйл ажиллагаатай холбоотойгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж ажиллана:

- хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах өдөр, цаг, газрыг тодорхойлон тогтоох;
- хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн жагсаалтыг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах;
- хувьцаа эзэмшигчдэд танилцуулах баримт материалыг хөтөлбөрийн дагуу хэвлэн бэлтгэх;
- хурлын хөтөлбөрийн дагуу санал өгөх журам болон саналын хуудсыг бэлтгэх;
- хувьцаа эзэмшигчдэд хурлын тов, хөтөлбөр болон холбогдох бусад материалуудыг хүргүүлэх.

4.2.3.Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлыг хурлын хөтөлбөрт тодорхой тусгаж өгсөн байх ёстой. Хөтөлбөр нь тодорхой бус жишээ нь “бусад”, “гэх мэтчилэн”, “өөр/төрөл бүрийн” гэдэг үгсийг хэрэглэхгүй байх нь зүйтэй.

4.2.4.Хувьцаа эзэмшигчдийг хурлаар хэлэлцэх асуудлын талаар шийдвэр гаргахад шаардлагатай бүхий л мэдээллээр хангасан байна.

4.2.5.Хувьцаа эзэмшигчдийн хурлыг үр дүнтэй хуралдуулахын тулд хурлын материалыг хувьцаа эзэмшигчдэд түргэн шуурхай цаг хугацаанд нь нэгэн зэрэг хүргүүлэх шаардлагатай тул тухайн хувьцаа эзэмшигчийн бүртгэлтэй цахим хаяг эсхүл шуудан болон холбоо харилцааны бусад тохиромжтой хэлбэрээ хүргүүлэх нь зүйтэй.

4.2.6.Компанийн саналын эрхтэй хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшдэг хувьцаа эзэмшигчид хурлын хөтөлбөрийн хэлэлцэх асуудалд нэмэлт оруулах боломжоор хангагдсан байна.

### **4.3. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах**

4.3.1.Хувьцаа эзэмшигчдэд хамгийн тохиромжтой байх байршил, цагийг сонгон хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулна. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь хувьцаа эзэмшигчид ажлаас хөндийрөлгүй оролцох боломжоор хангахын тулд долоо хоногийн амралтын өдрүүдэд зохион байгуулах нь зүйтэй.

4.3.2.Хувьцаа эзэмшигчдийн хурлыг өглөөний 10 цагаас эртгүй ба оройн 18 цагаас хойш бус байхаар товлано.

4.3.3.Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулах асуудлыг төлөөлөн удирдах зөвлөл хариуцна. Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга, хурлын нарын бичгийн дарга, тооллогын комиссыг төлөөлөн удирдах зөвлөлөөс томилно.

4.3.4.Хурлын дарга хурлын хөтөлбөрийг танилцуулснаар хурлыг эхлүүлнэ. Хурлын ирцийг тооллогын комисс хариуцан бүртгэж, хуралд мэдээлнэ. Холбогдох хууль тогтоомж, компанийн дүрмээр тогтоосон ирц хүрсэн тохиолдолд хурлыг эхлүүлж, хөтөлбөрийн дагуу хэлэлцэх асуудлыг хэлэлцэнэ.

4.3.5.Хурлын дарга оролцогчдод үг хэлэх бололцоогоор бүрэн хангах ба хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах журмыг чанд сахина. Хурлын дарга хурлын явцад гарах бүхий л зохион байгуулалтын асуудлыг шийдвэрлэнэ.

4.3.6.Хурлын хөтөлбөрт тусгасан асуудал тус бүрийг томилогдсон илтгэгч танилцуулах ба танилцуулах болон асуулт тавих хугацааг тогтоосон байна. Үүний дараа санал өгөх үйл ажиллагааг явуулна.

#### **4.4.Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр**

4.4.1.Хурлаас гарах шийдвэрийн агуулга хувьцаа эзэмшигчдэд тодорхой ойлгомжтой байх ёстой. Ингэснээр хэлэлцэж буй асуудалд санал өгөх үйл ажиллагаа шуурхай хялбар болох бөгөөд асуудлыг буруу ойлгох, үл ойлголцол гарах түүнээс шалтгаалан буруу шийдвэр гаргах зэргээс сэргийлнэ.

4.4.2.Хувьцаа эзэмшигч саналаа өгөхдөө ”зөвшөөрсөн”, “татгалзсан” гэсэн үгээр илэрхийлэх ба саналыг ил тод байдлаар эсвэл бичгээр авах гэсэн хэлбэрээр явуулж болно. Саналыг тухайн хувьцаа эзэмшигчийн саналын тоог тусгасан бөгөөд ”зөвшөөрсөн”, “татгалзсан” гэсэн үгээр илэрхийлэгдсэн урьдчилан бэлтгэн гаргасан саналын хуудсаар, бичгээр авах нь зүйтэй.

4.4.3.Санал хураалтын үр дүнг санал тоолох комисс нэгтгэн үр дүнг гаргана.

4.4.4.Саналын хуудаст дараах мэдээллийг тусгасан байна:

- компанийн нэр, хаяг;
- хурлын байр, байршил, өдөр, цаг;
- хурлын хөтөлбөр;
- хурлын хөтөлбөрт тусгагдсан асуудал бүрээр санал өгөх сонголтод ”зөвшөөрсөн”, “татгалзсан” гэсэн хариултыг ашиглана.

4.4.5.Хувьцаа эзэмшигч нь ”зөвшөөрсөн”, “татгалзсан” аль нэгийг сонгон саналаа өгнө.

4.4.6.Хурлын хөтөлбөрт тусгагдаагүй асуудлаар шийдвэр гаргахдаа батлахгүй байж болно. Иймд хөтөлбөрт тусгагдсан асуудал бүрт хувьцаа эзэмшигчид санал өгөх боломжийг хангах үүднээс хурлын дарга хэлэлцэх шаардлагатай бүх асуудлыг хурлын хөтөлбөрт бүрэн гүйцэд тусгах асуудлыг хариуцаж ажиллана. Хэлэлцэж буй асуудал тус бүрээр санал хураалт явуулна. Хоёр буюу түүнээс олон асуудлыг зэрэгцүүлэн санал хураалтыг явуулахыг хориглоно.

4.4.7.Хурлын шийдвэрийг компанийн бүх хувьцаа эзэмшигчдэд шуурхай хүргүүлнэ.

4.4.8.Хувьцаа эзэмшигч хуралд биеэр ирж чадахгүй тохиолдолд бичгээр саналаа өгөх ба "зөвшөөрсөн", "татгалзсан" үгсийн аль нэгийг сонгон илэрхийлж өөрийн гарын үсгийг зурсан байна. Биеэр оролцож чадахгүй тохиолдолд хэрхэн санал өгөх талаар хувьцаа эзэмшигчийн хурлыг зарлан хуралдуулах журамд тодорхой тусгасан байвал зохино.

#### **4.5.Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл**

4.5.1.Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлийг хурал хуралдсанаас хойш ажлын 3 хоногт багтаан гаргаж хурлын даргын гарын үсэг, тамгаар баталгаажуулах ба түүнчлэн тэмдэглэл хөтөлсөн хурлын нарын бичгийн даргын гарын үсэг зурагдсан байна.

4.5.2.Хэрэв хувьцаа эзэмшигч хурал хуралдсанаас хойш ажлын 5 хоногийн дотор бичгээр хурлын тэмдэглэлтэй танилцах хүсэлт гаргасан тохиолдолд түүнд тэмдэглэлийн хуулбарыг хүргүүлнэ.

### **ТАВДУГААР БҮЛЭГ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ**

#### **5.1.Төлөөлөн удирдах зөвлөлийн үүрэг**

5.1.1.Төлөөлөн удирдах зөвлөл нь хамтын удирдлага бүхий бүтэц бөгөөд үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна.

5.1.2.Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн үйл ажиллагааны стратегийг тодорхойлж түүний хэрэгжилтэд хяналт тавьж удирдамж, зөвлөмжөөр хангаж ажиллана.

5.1.3.Төлөөлөн удирдах зөвлөл хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө оруулалтыг хамгаалах, компанид үр ашигтай шийдвэр гаргах, компанийн үйл ажиллагааг хянах болон бодлого, стратегийг тодорхойлох зэргээр үүргээ хэрэгжүүлж ажиллана. Төлөөлөн удирдах зөвлөл гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавьж стратегийн удирдамж, чиглэлээр хангаж ажиллах ба дотоод хяналт, эрсдэлийн удирдлага, стратеги төлөвлөлт,

хууль тогтоомжийн хэрэгжилт, томоохон гэрээ, хэлцлүүд, компанийн өөрчлөн байгуулалт /нэгдэх, нийлэх, хуваах, тусгаарлах гэх мэт/ зэрэгт хяналт тавина.

5.1.4.Төлөөлөн удирдах зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн тэдгээрийг дүгнэх, урамшуулах, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдэд тавих шаардлага, төлөөлөн удирдах зөвлөлийн хурал түүнтэй холбоотой асуудлууд, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга, төлөөлөн удирдах зөвлөлийн хороодын үйл ажиллагаа болон бусад зөвлөлийн үйл ажиллагааны журмыг боловсруулан баталж, мөрдүүлэх нь зүйтэй.

## **5.2.Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх ба түүний бүтэц**

5.2.1.Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн үйл ажиллагааг зохистой удирдах, хяналт тавихад нийцэхүйц бүтэцтэй байна. Аудит эсвэл нягтлан бодох бүртгэл, санхүү, хууль эрх зүй, хөрөнгө оруулалтын чиглэлээр мэргэшсэн дадлага туршлага бүхий хувь хүнийг төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгон ажиллуулах нь зүйтэй.

5.2.2.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоо сондгой байхаар бүтцийг бүрдүүлэх нь зүйтэй. Энэ нь төлөөлөн удирдах зөвлөлийн үр дүнтэй үйл ажиллагааг дэмжиж ажиллах болон нөхцөл байдлыг өргөн цар хүрээтэй харж дүгнэлт гаргаж түүнийгээ үндэслэн оновчтой шийдвэр гаргах чадвар бүхий төлөөлөн удирдах зөвлөлийг бий болгох бөгөөд үүнтэй уялдуулан гишүүдийн тоог тогтооно.

5.2.3.Төлөөлөн удирдах зөвлөл нь хангалттай тооны /гуравны нэгээс доошгүй хувь/ хараат бус гишүүдтэй байна. Мэргэжлийн өндөр ур чадвар, туршлага бүхий гишүүдтэй, тэдний засаглалын талаарх мэдлэг боловсролыг байнга дээшлүүлж, ёс зүйн дүрмийг сахиулах талаар тодорхой арга хэмжээ авч ажилладаг төрийн бус, олон нийтийн хараат бус гишүүдийн жагсаалтаас сонгон авч, нэр дэвшүүлэн, сонгогдсон тохиолдолд тухайн байгууллагатай гэрээ байгуулан ажиллахыг урьтал болгох нь зүйтэй.

5.2.4.Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн дараах шалгуурыг хангасан байна. Үүнд:

- сүүлийн 5 жилд компанид болон түүний нэгдмэл сонирхолтой этгээд болж байгаагүй;
- компани эсвэл түүний нэгдмэл сонирхолтой этгээдийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэггүй;
- компани эсвэл түүний нэгдмэл сонирхолтой этгээдийн ханган нийлүүлэгч ба харилцагч бус;

- компани эсвэл түүний нэгдмэл сонирхолтой этгээдтэй үйлчилгээ үзүүлэх гэрээ хийгээгүй;
- компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын гишүүн, дотоод аудитын ажилтны нэгдмэл сонирхолтой этгээд бус;
- компанийн хувьцаа эзэмшигч эсвэл нэгдмэл сонирхолтой этгээдийн ойрын хамаатан бус;
- компанитай аливаа хэлбэрээр ажил, албан тушаал эрхэлдэггүй;
- компанийн аливаа хэлбэрийн бизнесийн гэрээ хэлцэл байгуулаагүй, тийм холбоогүй байх;
- компанийн дүрэмд заасан бусад шаардлага.

5.2.5.Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг хараат бус гишүүнээр сонгохыг эрмэлзэх нь зүйтэй.

5.2.6.Хараат бус гишүүдийн тоо нь компанийн шийдвэр гаргахад нөлөөлөх бололцоо бүхий зөвлөлийн бусад гишүүдийн тоотой тэнцвэртэй харьцаатай байх нь чухал. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд тавигдах мэргэжлийн өндөр ур чадвар, туршлагатай байх зэрэг шаардлагыг зөвлөл эсвэл компанийн дүрэмд тодорхойлж заасан байх нь зүйтэй.

### **5.3.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн үүрэг**

5.3.1.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, компанийн үр ашгийг нэмэгдүүлэх, хувьцаа эзэмшигчид ба компанийн эрх ашгийн төлөө үнэнч шударгаар ажилладаг байх үүрэгтэй. Зөвлөлийн гишүүд эрх үүргээ хэрэгжүүлэхдээ дараах шаардлагуудыг хангаж ажиллана:

- хууль тогтоомж, компанийн дүрэм, журам болон бусад холбогдох баримт бичигт заасан үүрэг хариуцлагаа хэрэгжүүлэхдээ компанийн эрх ашгийг дээдэлнэ.
- хууль тогтоомж компанийн дүрэм болон бусад холбогдох баримт бичигт заасан эрх мэдлийн хүрээнд үүргээ хэрэгжүүлнэ.
- компанийн үйл ажиллагаанд хяналт тавих зорилгоор төлөөлөн удирдах зөвлөлийн болон хороодын хуралдаан, компаниас зохион байгуулж буй бусад хэлэлцүүлэгт идэвхтэй оролцон хэлэлцэж буй асуудлын хүрээнд шаардлагатай мэдээ мэдээллийг олж авахын төлөө чармайж ажиллана. Зөвлөлийн гишүүд зөвлөлийн хурлын өмнө ирүүлсэн материалтай

урьдчилан танилцсан байх ба ялангуяа хөтөлбөрт заасан хэлэлцэх асуудлууд болон санхүүгийн баримт материалтай илүү нарийн танилцсан байна.

- компаниас ирүүлж буй мэдээ мэдээллээс гадна бие дааж судалгаа шинжилгээ хийх болон гадны мэргэжлийн шинжээч урих зэргээр үндэслэлтэй шийдвэр гаргахыг хичээнэ.
- компанийн өмнө хүлээсэн үүргээ хувийн ашиг сонирхлоос дээгүүрт үзэж, сонирхлын зөрчил үүсэхээс сэргийлэх бөгөөд эрх мэдлээ ашиглан хувьдаа ашиг олох, ямар нэг давуу байдал үүсгэхийг хориглоно.
- компанийн нууц болон дотоод мэдээллийг нийтэд нээлттэй болгох хүртэл чандлан нууцлах ба мөн түүнийг ашиглан орлого олохыг хориглоно.
- өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ мэдлэг ур чадвараа дайчлан, хичээл зүтгэл гарган ажиллана.

5.3.2.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн бүр аливаа чухал шийдвэр гаргахын өмнө шаардлагатай бүхий л мэдээ мэдээллээр цаг тухайд нь хангагдах ёстой.

5.3.3.Гишүүд үүргээ хэрэгжүүлэх боломжийг хангах үүднээс тодорхой асуудал хариуцсан эрх бүхий албан тушаалтан, захирлуудаас мэдээлэл, холбогдох материалыг шаардах эрхийг зөвлөлийн үйл ажиллагааны журамд зааж өгч болно.

#### **5.4.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, чөлөөлөх**

5.4.1.Төлөөлөн удирдах зөвлөлийг томилох журам нь ил тод нээлттэй байх ёстой. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгоход жижиг хувьцаа эзэмшигчдийн оролцоог хангах боломж бүрдүүлэх санал хураах аргыг ашиглан сонгуулийг явуулна.

5.4.2.Төлөөлөн удирдах зөвлөлийн бүх гишүүд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд заавал биечлэн оролцож, хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулт өгдөг байх үүргийг төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журамд тусгах нь зүйтэй. Энэ нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн мэдлэг туршлага, ур чадвар, хариуцлагын талаар хувьцаа эзэмшигчид дүгнэлт хийж, тэдгээрийг дахин сонгох эсэх талаар шийдвэрээ гаргахад төдийгүй төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн хариуцлагыг өндөржүүлэх ач холбогдолтой болно.

#### **5.5.Төлөөлөн удирдах зөвлөлийн хороод**



5.5.1.Компанийн засаглалын үр ашгийг нэмэгдүүлэх үндсэн суурь нөхцөл нь төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд дэх мэргэжлийн хороод /цаашид “Хороо” гэх/ бөгөөд хороод нь төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд дэмжлэг болох зорилгоор санал дүгнэлт гаргах үндсэн зорилготой бөгөөд зарим цөөхөн тохиолдолд шийдвэр гаргах эрх хэмжээтэй байна.

5.5.2.Хороо нь тухайн үйл ажиллагааг явуулах өндөр ур чадвар бүхий мэргэшсэн, туршлагатай 3-аас доошгүй гишүүдтэй байх ба компани нь дараах хороодтой байж болно:

- цалин урамшуулал болон нэр дэвшүүлэх хороо;
- аудитын хороо;
- эрсдэлийн удирдлагын хороо (энэхүү хорооны үйл ажиллагаа нь аудитын хорооны үйл ажиллагаатай хамт байж болно).

5.5.3.Эдгээрээс гадна өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон байнгын болон түр хороог байгуулан ажиллуулж болно.

5.5.4.Аудит, цалин урамшуулал болон нэр дэвшүүлэх хорооны дарга нь хараат бус гишүүн байх нь зүйтэй.

## **5.6.Төлөөлөн удирдах зөвлөлийн цалин урамшуулал болон нэр дэвшүүлэх хороо**

5.6.1.Цалин урамшуулал болон нэр дэвшүүлэх хороо нь чиг үүргээ хэрэгжүүлэхэд ур чадвараа дайчлан ажиллахад зөвлөлийн гишүүд болон гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааг идэвхжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулна. Үүний тулд удирдлагын баг, захирлууд, ахлах ажилтан, эрх бүхий албан тушаалтны цалин урамшууллын асуудлыг зохицуулах бодлогыг боловсруулахад дэмжлэг үзүүлж, батлах ба төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн үйл ажиллагаанд дүгнэлт өгч, урамшууллын асуудлыг авч үздэг байх ёстой. Цалин урамшууллын дараах хэлбэрийг авч үзэж зохистой хэм хэмжээг тогтоох ёстой:

- тогтмол цалин;
- хуралд ирсэн тохиолдол бүрд;
- хурал даргалах цалин;
- төлөөлөн удирдах зөвлөлийг удирдах цалин;
- компанийн жилийн үр дүнг үндэслэн нэг удаа олгох урамшилт цалин;
- хорооны үйл ажиллагаанд оролцсон тохиолдолд олгох цалин;

Компанийн үйл ажиллагааны чиглэл болон бусад нөхцөл байдлаас шалтгаалан өөр бусад урамшууллын хэлбэрийг авч үзэж болох юм.

5.6.2.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн үйл ажиллагааг үнэлж дүгнэх системийг боловсруулж батлан мөрдөх бөгөөд тайлангийн жил дууссаны дараа гишүүн бүрийн үйл ажиллагаанд дүгнэлт өгч, урамшууллын хэмжээг тогтоодог байх нь зүйтэй.

5.6.3.Цалин урамшуулал болон нэр дэвшүүлэх хороо нь гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын системийг тогтоож ажиллана. Энэхүү цалин урамшууллын систем нь хувьцаа эзэмшигчдийн эрх ашигт нийцсэн байна.

5.6.4.Удирдлагын багийн цалин урамшууллын систем нь урт хугацааны туршид тогтвортой үйлчлэхээр тогтоогдсон байх ба үүнийг компанийн дүрэм, гэрээнд тусгасан байх, эсхүл тусгайлан тогтоосон журамтай байна. Төлөөлөн удирдах зөвлөлөөс менежментийн багийн үйл ажиллагааг үнэлэх дүгнэх системийг боловсруулан гаргасан байна.

5.6.5.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шудрага зарчмаар сонгох болон гүйцэтгэх удирдлагын албан тушаалд нэр дэвшүүлэх ажлын зохион байгуулах зорилгоор нэр дэвшүүлэх хороог байгуулна.

5.6.6.Төлөөлөн удирдах зөвлөлд нэр дэвшүүлэх, сонгох үйл ажиллагааг хууль, журмын дагуу нээлттэй зарлах замаар ил тод явуулах нь зүтэй.

5.6.7.Цалин урамшуулал болон нэр дэвшүүлэх хороо нь гүйцэтгэх захирлын залгамж халааны бодлогын төслийг боловсруулж төлөөлөн удирдах зөвлөл батлан хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

## **5.7. Аудитын хороо**

5.7.1.Аудитын хороо дараах үйл ажиллагаанд хяналт тавьж энэхүү үйл ажиллагааны үр дүнг үндэслэн төлөөлөн удирдах зөвлөлд зөвлөмж гаргах, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, компанийн удирдлага ба дотоод болон хөндлөнгийн аудиторуудын үр ашигтай хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэх үүрэгтэй байна:

- компанийн санхүүгийн тайлан гаргах ажиллагаанд тавьж буй хяналтын үйл ажиллагаа;
- дотоод хяналтын системийн хэвийн үйл ажиллагаанд тавьж буй хяналтын үйл ажиллагаа;
- аудитын үйл ажиллагаанд тавьж буй хяналтын үйл ажиллагаа;
- холбогдох хууль, дүрэм, журмын хэрэгжилтэд тавьж буй хяналтын үйл ажиллагаанд хяналт тавих;
- компанийн эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих.

5.7.2.Аудитын хороо нь хөндлөнгийн аудиторыг нэр дэвшүүлж төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулна.

#### **5.8.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн сонирхлын зөрчил ба нэгдмэл сонирхолтой этгээд хоорондын хэлцлүүд**

5.8.1.Компани нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх хэлцэл ба сонирхлын зөрчлийг зохицуулах бодлоготой байна. Түүнчлэн төлөөлөн удирдах зөвлөлийн ёс зүйн кодексийг батлан мөрдөнө. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн хувийн болон санхүүгийн сонирхол компанийн эрх ашгийг нэн тэргүүнд тавих үүргийн хооронд сонирхлын зөрчил гарах тохиолдол байдаг.

5.8.2.Тодорхой асуудлаар шийдвэр гаргах үед төлөөлөн удирдах зөвлөлийн аль нэг гишүүн эсхүл хэсэг гишүүдийн хувьд дээр дурьдсан сонирхлын зөрчил үүсэж байгаа бол энэ тухайгаа зөвлөлд мэдэгдэж тухайн асуудалд санал өгөхгүй. Төлөөлөн удирдах зөвлөл их хэмжээний сонирхлын зөрчилтэй хэлцлийг баталж байгаа тохиолдолд хувьцаа эзэмшигчид болон нийтэд мэдээлж ил тод болгосон байх ёстой.

#### **5.9.Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын үүрэг**

5.9.1.Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь дараах үүрэгтэй байж болно:

- компанийн засаглалын талаар бодлого боловсруулахад оролцох;
- бүрэн эрхийнхээ хүрээнд компанийн ажилтнууд компанийн засаглалын бодлогыг дагаж мөрдөх;
- компанид сайн засаглалын практикийг хэвшүүлэх үйл явцыг удирдан чиглүүлэх арга хэмжээ авах;
- хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл болон түүний хороодын хуралд бэлтгэх, зарлах, хуралдуулах арга хэмжээг зохион байгуулах;
- мэдээллийг нийтэд хүргэх арга хэмжээ авах замаар компанийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах;
- хувьцаа эзэмшигч болон бусад оролцогч талаас төлөөлөн удирдах зөвлөлд ирүүлсэн аливаа санал, гомдол хүсэлтийг шийдвэрлэхэд оролцох;
- компани доторх маргааныг шийдвэрлэх талаар холбогдох арга хэмжээ авах, санал боловсруулах.

5.9.2.Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга наад зах нь дараах шаардлагыг хангасан байна:

- Дээд боловсролтой;
- Нарийн бичгийн даргын үүрэг хариуцлагыг гүйцэтгэхэд шаардлагатай ажлын туршлага болон мэргэжлийн ур чадвартай;
- Холбогдох хууль тогтоомжийн талаар мэдлэгтэй;
- Холбогдох хуулийн шаардлагыг хангасан;
- Компанитай нэгдмэл сонирхолгүй, компанийн томоохон хувьцаа эзэмшигчдээс хараат бус этгээд байх.

## **ЗУРАВДУГААР БҮЛЭГ. ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА**

### **6.1. Гүйцэтгэх удирдлагын эрх**

6.1.1.Гүйцэтгэх удирдлага нь компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан чиглүүлж, компанийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд байх бөгөөд түүнийг гүйцэтгэх захирал, эсхүл гүйцэтгэх удирдлагын багийн аль нэг хэлбэрээр хэрэгжүүлнэ.

6.1.2.Гүйцэтгэх удирдлагын эрх хэмжээ нь түүний төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээний үнхдсэн дээр хэрэгжих бөгөөд уг гэрээнд гүйцэтгэх удирдлагын эрх үүрэг, хэрэгжүүлэх хугацаа, хуриуцлагын хэмжээ, хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, цалин хөлс, урамшууллыг тусгасан байна.

6.1.3.Гүйцэтгэх удирдлага ба удирдлагын багийн гишүүд компанийн төлөө үнэнч шудрагаар ашиг сонирхлын зөрчилгүй ажиллана.

## **ДОЛДУГААР БҮЛЭГ. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ**

### **7.1.Санхүүгийн тайлагнал**

7.1.1.Санхүүгийн тайлагналын үндсэн зорилго бол компанийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих замаар хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэх явдал. Компани тайлагнах үйл ажиллагаандаа олон улсын санхүүгийн тайлагналын стандартыг мөрдөх нь орчин үеийн санхүүгийн тайлагналын системийг төлөвшүүлэх боломж

бүрдүүлнэ. Компани найдвартай санхүүгийн тайлагналын системийг бий болгохын тулд дараах шаардлагуудыг мөрдөнө:

- олон улсын стандартад нийцсэн нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг баталж мөрдөх;
- дотоод хяналтын тогтолцоог бий болгох;
- компанийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог бий болгох;
- компанийн гүйцэтгэх ажилтан нарыг санхүүгийн хууль бус үйл ажиллагаа, хөрөнгө ашиглах шамшигдуулахаас урьдчилан сэргийлэх, хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах;
- компанийн үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдал, найдвартай байдлыг хангах.

## **7.2. Хөндлөнгийн аудит**

7.2.1.Хөндлөнгийн аудитор нь сонирхлын зөрчлөөс ангид бие даасан хараат бус мэргэжлийн өндөр ур чадвартай байна.

7.2.2.Хөндлөнгийн аудитор аудитын дүгнэлт гаргах үйлчилгээ үзүүлэх ба сонирхлын зөрчил үүсгэх /татварын асуудал гэх мэт/ асуудлуудаас бусад аудитын бус үйлчилгээг үзүүлж болох ба түүний үйлчилгээний хөлс нь аудитын дүгнэлт гаргах үйлчилгээний нийт хөлсөөс хэтэрч болохгүй. Хөндлөнгийн аудитор нь олон улсын аудитын стандартын дагуу үйл ажиллагаагаа явуулна.

7.2.3.Хөндлөнгийн аудиторыг хувьцаа эзэмшигчдийн хурлаас томилох нь зүйтэй бөгөөд хөндлөнгийн аудитыг томилох үйл ажиллагааг зохицуулсан дотоод журамтай байна.

7.2.4.Компанийн аудитын үйл ажиллагааг явуулах хөндлөнгийн аудитын компанийн аудиторыг 5 жилийн хугацаатай сонгон ажиллуулах ба тухайн компанийн өөр аудиторыг сонгон ажиллуулах эсвэл шаардлагатай гэж үзвэл тухайн аудитын компанаас өөр компанийг сонгон ажиллуулж болно.

7.2.5.Хөндлөнгийн аудиторыг энэ хугацаанаас өмнө компани эсхүл аудиторын санаачилгаар солихоор болсон тохиолдолд солисон талаар нийтэд мэдээлдэг журам тогтоосон байна.

## **7.3.Мэдээллийн ил тод нээлттэй байдал**

7.3.1.Төлөөлөн удирдах зөвлөл компанийн үйл ажиллагааны талаарх мэдээллээр хувьцаа эзэмшигчдийг болон бусад сонирхогчид эрх бүхий хяналт зохицуулалтын байгууллагыг цаг тухай бүр, бүрэн хангах талаар журам тогтоон ажиллана.

7.3.2.Компани зөвхөн хуулийн шаардлагыг хангах бус мөн олон улсын сайн туршлагын дагуу бизнесийн тодорхойлолт, санхүүгийн нөхцөл байдлын дүн шинжилгээ, үйл ажиллагааны үр дүн, хөрөнгийн өөрчлөлт, бэлэн мөнгөний урсгал болон аливаа материаллаг эрсдэлүүд ба эрсдэлийн хүчин зүйлсийг нээлттэй болгосон мэдээллүүдийг жилийн тайландаа тусгасан байна.

7.3.3.Компани болсон үйл явдал болон дунд хугацааны үр дүнг ил тод мэдээлнэ. Компани өөрийн вэб сайтаар дамжуулан мэдээллийг ил тод байлгах ба өөрсдийн жилийн тайланг албан ёсны сайт дээр байршуулан мэдээлнэ.

7.3.4.Компанийн мэдээллийн ил тод байдлын бодлогыг тодорхойлж нийтэд мэдээлж ил тод болгоно.

7.3.5.Компани дотоод мэдээлэл эсвэл нууцлалын зэрэглэлийн мэдээллийн талаар холбогдох хууль журамд тусгасан заалтууд зөрчигдөж байгаа эсэхэд тогтмол хяналт тавина.

## **НАЙМДУГААР БҮЛЭГ. ДОТООД ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО**

### **8.1. Дотоод хяналтын тогтолцоо ба дотоод аудитын үйл ажиллагаа**

8.1.1.Компани мэдээллийн ил тод нээлттэй байдал ба мэдээллийг баталгаажуулах дотоод хяналтын тогтолцоог бий болгосон байна. Төлөөлөн удирдах зөвлөл компанийн санхүүгийн зорилт ба хэрэгжилтийн үр дүнг баталгаажуулах дотоод хяналтын найдвартай системээр хангах ёстой.

8.1.2.Дотоод хяналтын тогтолцоо нь компанийн удирдлагын үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх болон компанийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг дүгнэн түүний дагуу удирдамж заавраар газар хэлтсүүдийг хангадаг байна. Дотоод хяналт нь дараах асуудалд чиглэсэн үйл ажиллагааг явуулна:

- санхүүгийн тайлангийн бодит байдал, мэдээллийн системийн найдвартай ажиллагааг хангах;
- компанийн эрсдэлийг үнэлэх үйл ажиллагаа;
- компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх;
- хууль, журам, стандартын хэрэгжилтэд хяналт тавих;

- ажлын байрны хөдөлмөр хамгааллын аюулгүй байдал түүний үйл ажиллагааны горимын хэрэгжилтийг хангуулах түүнд хяналт тавих;
- дотоод хяналтын үйл ажиллагааны тайланг төлөөлөн удирдах зөвлөлд тайлагнах.

8.1.3.Компани дотоод хяналтын тогтолцооны нэг хэсэг болох дотоод аудитын газартай байна. Дотоод аудитын үйл ажиллагаандаа дараах зарчмуудыг удирдлага болгоно.

- санхүүгийн болон үйл ажиллагааны мэдээллийн найдвартай, нэгдмэл байдлын хангах;
- үр ашигтай үйл ажиллагаа;
- хөрөнгийн бүрэн бүтэн найдвартай байдал;
- хууль, компанийн бодлого ба дүрэм, журмын хэрэгжилтийг хангах.

8.1.4.Дотоод аудитын газар байгууллагын бүхий л түвшинг хамарсан хяналт шалгалт явуулах, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын тогтолцоонд мониторинг хийх чиг үүрэгтэй байх бөгөөд гүйцэтгэх удирдлагаас хараат бус бие даасан, өндөр мэргэшсэн ажилтнуудын бүрэлдэхүүнтэй байна.

8.1.5.Монгол улсын хууль эрх зүйн зохицуулалтын хүрээнд болон Дотоод аудиторын олон улсын институтийн /ДАОУИ/ баталсан стандартын дагуу дотоод аудитын үйл ажиллагааг явуулна.

## **ЕСДҮГЭЭР БҮЛЭГ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА**

9.1.Төлөөлөн удирдах зөвлөл нь гадаад ба дотоод үйл ажиллагааны бүхий л эрсдэл, санхүү ба хуулийн хэрэгжилт болон бусад эрсдэлийг эрсдэлийн менежментээр хангах нэгдсэн үйл ажиллагааг хариуцна.

9.2.Төлөөлөн удирдах зөвлөл нь гарах эрсдэлүүдийг тодорхойлж үнэлэн дүн шинжилгээ хийх болон түүний нөлөөллийг тодорхойлох зэрэг үйл ажиллагааг явуулах асуудлыг компани хариуцах болохыг баталгаажуулах ба тэдгээр эрсдэлийг бууруулах болон авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээг батална.

9.3.Удирдлагын баг эрсдэлийн удирдлагын журам, дүрмийг боловсруулан хэрэгжүүлж хэрэгжилтэд хяналт тавих асуудлыг хариуцна.

## АРАВДУГААР БҮЛЭГ. ОРОЛЦОГЧ ТАЛУУД

10.1.Компани оролцогч талуудын (ажилчид, зээлүүлэгчид, харилцагчид, ханган нийлүүлэгчид, орон нутгийн иргэд болон ард иргэд) эрхийг хүндэтгэнэ. Компани ажилчид, зээлүүлэгчид, ханган нийлүүлэгчид, худалдан авагчид, үйлчлүүлэгчдийн сонирхол болон байгаль орчин, нийгмийн хариуцлагын асуудлуудыг харгалзан гаргах гэж буй шийдвэрүүд нь оролцогч талуудад нөлөөлөх эсэхийг харгалзан шийдвэр гаргадаг байх ёстой.

10.2.Компани оролцогч талуудыг компанийн төлөвлөгөө, тайлан гэх мэт мэдээллүүдтэй танилцах боломжоор хангасан байна.

10.3.Компани оролцогч талуудтай холбоотой хууль, дүрэм гэрээ хэлцлийг мөрдөж ажиллах ба хууль, журамд заасан оролцогч талуудын эрх ашгийг зөрчсөн үйл ажиллагаа явуулахгүй.

10.4.Компани нь оролцогч талуудын үр дүнтэй харилцаа холбоог хангахын тулд хууль болон олон улсын сайн туршлагын дагуу санхүүгийн бус мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллана.

10.5.Ажилтнуудын санал хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэх, тэдний нийгмийн асуудал, мэргэжил мэргэшлийг дээшлүүлэх төлөвлөгөөтэй ажиллана.

10.6.Компани нь оролцогч талуудтай холбоотой эдийн засаг, нийгэм болон байгаль орчны (жишээ нь авилгын эсрэг бодлого, хөдөлмөрийн бодлого, ханган нийлүүлэгчид ба харилцагчдын харилцаа холбоог зохицуулах бодлого, компанийн нийгмийн хариуцлагын бодлого, байгаль орчныг хамгаалах бодлого гэх мэт) асуудлуудын талаарх мэдээллийг ил тод мэдээлнэ.

---oOo---